БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/177/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2022 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Аудитор: Х.Еркебулан<br>Утас: 92921881 Цахим хаяг:erkebulankh@ audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................................4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........................................................5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........................................................6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........................................................8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан........................................................8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........................................................10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан........................................................12
3. Аудитын тайлан........................................................13
3.1 Ерөнхий зүйл........................................................13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........................................................13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................................14
3.4 Материаллаг байдал ........................................................14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........................................................14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........................................................15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........................................................16
3.8 Аудитын гол асуудал ........................................................17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........................................................17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт........................................................17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........................................................17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........................................................17
4. Аудитын илрүүлэлт ........................................................18
4.1 Залруулсан алдаа........................................................18
4.2 Төлбөрийн акт........................................................18
Байхгүй ........................................................**Error! Bookmark not defined.**
4.3 Албан шаардлага ........................................................18
4.4 Зөвлөмж ........................................................18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........................................................19

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2022.02.18 № 77

танай____________-ны № ______________-т

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Г. АМАНТАЙ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Боловсролын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Боловсролын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

Боловсролын газар-Дүгнэлт

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **69256594.35** | **122996837.94** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 6863829.60 | 6241269.60 |
| **354** | **Хангамжийн материал** | 6863829.60 | 6241269.60 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1090110.00 | 571050.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4673720.00 | 4570220.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1099999.60 | 1099999.60 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 62392764.75 | 116755568.34 |
| 36800 | Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/ | 62392764.75 | 116755568.34 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **73466047.13** | **82424047.40** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 73466047.13 | 82424047.40 |
| **392** | **Биет хөрөнгө** | 65786047.13 | 74744047.40 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1927800.00 | 0.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -257040.00 | 0.00 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 117937075.00 | 117937075.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -86297075.00 | -89657075.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 135241935.32 | 99595194.92 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -116758036.35 | -63404722.10 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 59531865.00 | 43074001.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -45540476.84 | -32800426.42 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 7680000.00 | 7680000.00 |
| 39301 | Програм хангамж | 742500.00 | 550000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -742500.00 | -550000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7680000.00 | 7680000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **142722641.48** | **205420885.34** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **142722641.48** | **205420885.34** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 142722641.48 | 205420885.34 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 253829745.73 | 253829745.73 |
| 51101 | Өмч: - төрийн | 253829745.73 | 253829745.73 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -129393204.25 | -62811760.39 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -215295609.98 | -125510004.25 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 85902405.73 | 62698243.86 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 18286100.00 | 14402900.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **142722641.48** | **205420885.34** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2692850052.98** | **3714965983.38** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **182254005.98** | **162040707.38** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 182254005.98 | 162040707.38 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 182254005.98 | 162040707.38 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 182254005.98 | 162040707.38 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2510596047.00** | **3552925276.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2416015900.00 | 3119684300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2416015900.00 | 3119684300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 94580147.00 | 433240976.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 56170387.00 | 120145368.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 36204480.00 | 313095608.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2205280.00 | 0.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2606947647.25** | **3649242327.36** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2606947647.25** | **3649242327.36** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 554568385.35 | 900625201.42 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 317772351.08 | 330845323.68 |
| 210101 | Үндсэн цалин | 205915322.32 | 203039435.54 |
| 210102 | Нэмэгдэл | 95734033.40 | 107650630.42 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 11815251.09 | 12155257.72 |
| 210104 | Урамшуулал | 4307744.27 | 8000000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37295163.00 | 40927353.34 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21375778.00 | 29968358.69 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7186785.00 | 2858153.23 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2328700.00 | 2286282.61 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 582200.00 | 571870.65 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5821700.00 | 5242688.16 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22203981.02 | 23841152.04 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1964300.00 | 1998118.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19465681.02 | 21085016.04 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 774000.00 | 758018.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 101737891.23 | 166872501.79 |
| 210401 | Бичиг хэрэг | 845500.00 | 15544438.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16470650.00 | 19802550.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 622600.00 | 443210.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 300000.00 | 6000000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 80000.00 | 22766800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 619100.00 | 498900.00 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | 82800041.23 | 101816603.79 |
| **2105** | **Нормативт зардал** | 0.00 | 1900000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 0.00 | 1900000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5180000.00 | 13186560.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 5000000.00 |
| 210602 | Тавилга | 5000000.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 180000.00 | 8186560.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 0.00 | 4032000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 0.00 | 4032000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 36442870.00 | 24413855.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 36442870.00 | 24413855.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 33936129.02 | 294606455.57 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 113990.00 | 471800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 20367780.00 | 277556768.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 13454359.02 | 16577887.57 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2052379261.90 | 2748617125.94 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1985803625.00 | 2368140038.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 47262000.00 | 0.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 790210325.00 | 1166715988.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 1146605900.00 | 1201096050.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1725400.00 | 328000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 66575636.90 | 380477087.94 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 66575636.90 | 380477087.94 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **85902405.73** | **65723656.02** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 0.00 | 3025412.16 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 0.00 | 3025412.16 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 0.00 | -3025412.16 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **85902405.73** | **62698243.86** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 253,829.745.73 | 18,286,100 | -129,393,204.25 | 142,722,641.48 |
| **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 253,829.745.73 | 18,286,100 | -129,393,204.25 | 142,722,641.48 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | -3,883,200.0 | -3,883,200.0 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 253,829.745.73 | 18,286,100 | -125,510,004.25 | 146,605,841.48 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,  бууралт | | -3,883,200.0 | | -3,883,200.0 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | 0.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | 0.00 |
| Тайлант үеийн үр дүн | | | 62,698,243.86 | 62,698,243.86 |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **253,829.745.73** | **14,402,900.00** | **-62,811,760.39** | **205,420,885.34** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2510596047.00** | **3552925276.00** |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2510596047.00** | **3552925276.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2416015900.00 | 3119684300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2416015900.00 | 3119684300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 94580147.00 | 433240976.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 56170387.00 | 120145368.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 36204480.00 | 313095608.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2205280.00 | 0.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2510596047.00** | **3530225276.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2510596047.00** | **3530225276.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **458216785.10** | **781608150.06** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 315771214.08 | 330845323.68 |
| 210101 | Үндсэн цалин | 202985170.02 | 203039435.54 |
| 210102 | Нэмэгдэл | 95734033.40 | 107650630.42 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12744266.39 | 12155257.72 |
| 210104 | Урамшуулал | 4307744.27 | 8000000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 39296300.00 | 40927353.34 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27652900.00 | 29968358.69 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2910800.00 | 2858153.23 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2328700.00 | 2286282.61 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 582200.00 | 571870.65 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5821700.00 | 5242688.16 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22179981.02 | 23841152.04 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1964300.00 | 1998118.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19441681.02 | 21085016.04 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 774000.00 | 758018.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18223900.00 | 64433338.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 939500.00 | 15025378.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15829900.00 | 19802550.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 622600.00 | 443210.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 300000.00 | 6000000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 80000.00 | 22766800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 451900.00 | 395400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 0.00 | 1900000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 0.00 | 1900000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5180000.00 | 13186560.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 5000000.00 |
| 210602 | Тавилга | 5000000.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 180000.00 | 8186560.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 0.00 | 4032000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 0.00 | 4032000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 36442870.00 | 24413855.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 36442870.00 | 24413855.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 21122520.00 | 278028568.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 113990.00 | 471800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 21008530.00 | 277556768.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2052379261.90** | **2748617125.94** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1985803625.00 | 2368140038.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 47262000.00 | 0.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 790210325.00 | 1166715988.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 1146605900.00 | 1201096050.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1725400.00 | 328000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 66575636.90 | 380477087.94 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 66575636.90 | 380477087.94 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **0.00** | **22700000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **0.00** | **22700000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.00** | **22700000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 0.00 | 22700000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 0.00 | 22700000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **0.00** | **-22700000.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **0.00** | **0.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | 0.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 3119684300.00 | 2741494949.33 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 3119684300.00 | 2741494949.33 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 380632700.00 | 373354911.33 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 298197800.00 | 297332988.95 |
| 210101 | Үндсэн цалин | 227131400.00 | 196193767.81 |
| 210102 | Нэмэгдэл | 53022000.00 | 80983963.42 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13200000.00 | 12155257.72 |
| 210104 | Урамшуулал | 4844400.00 | 8000000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 40256800.00 | 37594020.34 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29706400.00 | 26635025.69 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2637600.00 | 2858153.23 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2110100.00 | 2286282.61 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 527500.00 | 571870.65 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5275200.00 | 5242688.16 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27542000.00 | 23841152.04 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2802400.00 | 1998118.00 |
| 210302 | Түлш, халаалт | 22963800.00 | 21085016.04 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1775800.00 | 758018.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4405200.00 | 4391020.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 526800.00 | 526800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1815600.00 | 2492410.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 654200.00 | 443210.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 480000.00 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 533200.00 | 533200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 395400.00 | 395400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1900000.00 | 1900000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1900000.00 | 1900000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 144000.00 | 144000.00 |
| 210604 | Урсгал засвар | 144000.00 | 144000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1434000.00 | 1398830.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1434000.00 | 1398830.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6752900.00 | 6752900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 471800.00 | 471800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6281100.00 | 6281100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2739051600.00 | 2368140038.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2739051600.00 | 2368140038.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 1507780100.00 | 1166715988.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 1230943500.00 | 1201096050.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 328000.00 | 328000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3119684300.00 | 2741494949.33 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3119684300.00 | 2741494949.33 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 3119684300 | 2741494949 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 0.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.00 | 0.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 22.00 | 24.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 18.00 | 20.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3.00 | 3.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **22.0** | **24.0** |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 14.00 | 16.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 8.00 | 8.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **430953238.73** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **430953238.73** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 430953238.73 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 33512334.73 |
| Үндсэн цалин | 6,845,667.73 |
| Нэмэгдэл | 26,666,667.00 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 3333333.00 |
| Тэтгэврийн даатгал | 3,333,333.00 |
| **Хангамж, бараа материалын зардал** | 60042318.00 |
| Бичиг хэрэг | 14,498,578.00 |
| Тээвэр, шатахуун | 17,310,140.00 |
| Ном, хэвлэл | 6,000,000.00 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 22,233,600.00 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 35742560.00 |
| Багаж, техник, хэрэгсэл | 27,700,000.00 |
| Урсгал засвар | 8,042,560.00 |
| **Томилолт, зочны зардал** | 4032000.00 |
| Дотоод албан томилолт | 4,032,000.00 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 23015025.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 23,015,025.00 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 271275668.00 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 271,275,668.00 |
| **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **2287737.27** |
| Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 2,287,737.27 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 433240976.00 |
| **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 433240976.00 |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 120,145,368.00 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 313,095,608.00 |
| **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Боловсролын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

Боловсролын газрын эрхэм зорилго нь иргэн бүрийг бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болон төлөвшүүлэх, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх таатай орчныг бий болгох замаар хүний хөгжилд дэмжлэг үзүүлэх явдал мөн.

- Боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах.
- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар дүгнэлт гаргаж, аймгийн Засаг даргад санал болгох
- Багш, сурагчдын хөдөлмөрийг бодитой үнэлж шагнаж урамшуулах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг олгох
- Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих
- Орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэгийн хамран сургах тойрог тогтоох

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Боловсрол газарт хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын комисс ажилладаг. Тус комисс нь байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, алба, салбар нэгжийн үйл ажиллагаанд гарч буй зөрчил, дутагдлыг арилгаж, шалгалтын мөрөөр тодорхой ажил зохион байгуулах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, анги, байгууллагын тодорхойлсон эрсдэлийг нэгтгэн, байгууллагын эрсдэлийн үнэлгээг тогтоож, тайланг Боловсролын Шинжлэх Ухааны Яам болон Боловсролын газрын дотоод хяналт шалгалтын хэлтэст хүргүүлдэг байна.

Тус газарт 2021 онд дотоод аудитын шалгалт ирээгүй  бусад эрх бүхий байгууллагуудаас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2606.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 39.1 сая  төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 27.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Боловсролын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 62.7 сая төгрөгөөр буюу  30.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн  данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |

| | | | |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 0.00 | 0.00 | 0.00 |
| Авлага | 0.00 | 0.00 | 0.00 |
| Урьдчилгаа | 0.00 | 0.00 | 0.00 |
| Бараа материал | 69256.6 | 122996.8 | 53740.2 |
| Үндсэн хөрөнгө | 73466.0 | 82424.0 | 8958.0 |
| **Нийт хөрөнгө** | **142722.6** | **205420.8** | **62698.2** |
| Өр төлбөр | 0.00 | 0.00 | 0.00 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 142722.6 | 205420.8 | 62698.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **142722.6** | **205420.8** | **62698.2** |

Мөнгөн хөрөнгийн болон авлагын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 122.9 сая төгрөг болж 53.6 сая төгрөгөөр нэмэгджээ. Тайлант онд 4.5 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй 156.2 сая төгрөгийн бараа материал хүлээн авч үйл ажиллагаандаа 106.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 82.4 сая төгрөг болж 8.9 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 22.7 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, үнэ төлбөргүй 5.9 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, 82.8 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж, үндсэн хөрөнгөнд 16.6 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Өр төлбөр данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 205.4 сая төгрөг болж 62.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 62.7 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 3714.9 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 1022.1 сая төгрөгөөр буюу 27.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, санхүүжилтийн орлого, нэмэлт санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 1042.3 сая төгрөгөөр буюу 28.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглахтай холбоотой зардал, хангамжийн бараа материалын зардал, норматив зардал, эд хогшил, урсгал засварын зардал, урсгал шилжүүлэг зэрэг зардлууд байна. Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглахтай холбоотой зардал, хангамжийн бараа материалын зардал, норматив зардал, эд хогшил, урсгал засварын зардал, урсгал шилжүүлэг зардлууд өмнөх оноос нэмэгдэж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлууд өмнөх оноос буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны анх батлагдсан төсөв 3075.0 сая төгрөг, тодотгосон төсөв 3119.7 сая төгрөг байна.

Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 44.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 34.4 сая төгрөг, нийгмийн даатгалын

шимтгэлийн зардал 4.7 сая төгрөг, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл зардлыг 1.9 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3.7 сая төгрөгөөр нэмж, хангамж, бараа материалын зардал 0.6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 0.06 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 0.8 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Цалингийн зардал нэмэгдсэн нь 2 үйлчилгээний ажилтан 2019 онд шүүхийн шийдвэрээр ажилд эргүүлэн томилогдсонтой холбоотой зохицуулалт хийжээ.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 3119.7 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 2741.5 сая төгрөгийг зарцуулж, 378.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Энэ нь үндсэн цалин, нийгмийн даатгалын шимтгэл, гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус, шуудан холбоо, интернэтийн төлбөр, ном хэвлэл, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийн зардлын хэмнэлт байна.

Нийт төсвийн 10.8 хувийг цалин, 1.4 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 0.9 хувийг тогтмол зардал, 0.2 хувийг хангамж бараа материалын зардал 0.3 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 86.4 хувийг урсгал шилжүүлэг тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Боловсрол Шинжлэх Ухааны яамнаас 47.4 сая төгрөгийн, Боловсролын чанарын шинэчилсэн төслөөс 229.0 сая төгрөг, Боловсролын мэдээллийн технологийн төвөөс 19.0 сая төгрөг, Боловсролын үнэлгээний төвөөс 17.7 сая төгрөг, Аймгийн Засаг даргын тамгын газраас 120.1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авчээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 33.5 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 3.3 сая төгрөг, бичиг хэрэгт 14.5, шатахууны зардалд 17.3 сая төгрөг, ном хэвлэл 6.0 сая төгрөг, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал зардалд 22.2 сая төгрөг, урсгал засварын зардалд 35.7 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 23.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 271.3 сая, нийт 430.9 сая төгрөгийг зарцуулж, нэмэлт санхүүжилтийн данснаас 2.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Боловсролын газар 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна. Байгууллага үйл ажиллагаатай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдол гараагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтад хамаарах Боловсролын газрын байгууллагын үндсэн

үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн 10 хувь 1767.1 мянган төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй, Засгийн газрын тогтоолын 1.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### 3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Боловсролын газар нь 2021 онд нийт 3552.9 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 3539.3 сая төгрөгийн 119 мэдээллийг ил тод байршуулсан, 1 мэдээллийг хугацаа хоцроож нөхөж байршуулсныг шалгаж үзэхэд мэдээллээ засаж байршуулсантай холбоотой байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш 13.6 сая төгрөгийн 1 гүйлгээ гарсныг мэдээлээгүй ба тэтгэмжийн зардалтай холбоотой нийт 2381.4 сая төгрөгийн 345 гүйлгээ гарсныг бүрэн байршуулсан байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх онд зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1.8 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага тогтоож, 13.6 сая төгрөгийн зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Боловсролын газар нь 2021 онд нийт 3119684.3 мянган төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 2741494.9 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 378189.3 мянган төгрөгийг төсөв буцаан төвлөрүүлжээ.

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтад хамаарах Боловсролын газрын байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн 10 хувь 1767.1 мянган төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Аудитаар шилэн данстай холбоотой зөрчилд 1 зөвлөмж өгөв. Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Шилэн данстай холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:*

Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш 13.6 сая төгрөгийн 1 гүйлгээ гарсныг мэдээлээгүй орхигдуулсан байна.

*1.2. Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын холбогдох заалтуудыг мөрдөж ажиллах, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд бүрэн оруулж зөрчлийг арилгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Боловсролын газар | 2 | 15.4 | | | | | 1 | 1.8 | 1 | 13.6 |
| **Нийт дүн** | | **2** | **15.4** | | | | | **1** | **1.8** | **1** | **13.6** |